



ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ

ГЭГЭЭН ОЛОН УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТӨВ



ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Ихэнх улс өөрсдийн гэсэн Засгийн газрын нэрэмжит тэтгэлгүүдийг зарладаг бөгөөд холбоотон улсуудтайгаа хамтран чадварлаг мэргэжилтэн бэлтгэх зориолгоор жил бүр зарладаг. Ихэнх тохиолдолд бүтэн тэтгэлэг олгодог. Бүтэн тэтгэлэг гэдэгт сургалтын төлбөр, нисэх онгоцны зардал, сар бүрийн тэтгэмж, дотуур байр зэрэг багтана:

АВСТРАЛИ УЛСАД
БАКАЛАВРЫН ТҮВШИНД
ТЭТГЭЛЭГ АВАХАД
ЮУ ЮУ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- АКАДЕМИК ШАЛГАЛТЫН ОНОО:
- ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ АЖИЛ
- ХУВИЙН ЭСЭЭ
- ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ
- ХЭЛНИЙ ОНОО



АКАДЕМИК ШАЛГАЛТЫН ОНОО



Австралийн Их сургуулиуд хамгийн түрүүнд өмнө нь суралцсан газрын голч дүн, гаргасан амжилтанд голчлон тулгуурлаж шийдвэрээ гаргадаг. Ойролцоо 70+ голчтой бол 15%-ийн тэтгэлэг, 85% голчтой бол 30%-ийн тэтгэлэг олгодог гэх мэт.

ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ АЖИЛ



Ихэнх Австралийн Их сургуулиуд элсэлт авахдаа сурагчийн хичээлээс гадуурх ажилд ач холбогдол өгдөггүй боловч, тэтгэлэг олгоход гол шалгуур байх магадлалтай.

Сонирхож буй чиглэлээр ямар нэгэн төсөл хэрэгжүүлсэн эсвэл клубийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог, хүрээлэн буй орчиндоо тодорхой хэмжээний хувь нэмэр оруулсан байвал давуу тал болно.



ХУВИЙН ЭСЭЭ:

Та тухайн сургуульд элсэж орохын тулд олон улсын оюутануудтай өрсөлдөж байгаа тул та өөрийнхөө сонирхол, өвөрмөц байдал, хувь хүний онцлог, манлайлах чадвараа олон талаас харуулах шаардлагатай. Таныг ямар хүн бэ гэдгийг хувийн эсээ тань тухайн их сургуулийн тэтгэлгийн хорооны гишүүдэд харуулах боломж байдаг тул энгийн эсээ бичих биш, өөрийгөө хэн бэ гэдгийг маш сайн харуулаж чадсан чанартай эсээ бичих хэрэгтэй.



ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

Ихэнхи тохиолдолд ахлах сургуулийн багш,
нийгмийн ажилтны бичсэн тодорхойлолт
байдаг.

Энэ захидал нь өвөрмөц, суралцагчийг өөр хүний
өнцгөөс харулж чадсан байвал зохино.



ХЭЛНИЙ ОНОО

Австралийн Их сургуулийн хувьд суралцагч зохих түвшний хэлний мэдлэгийг эзэмшсэн эсэх нв маш чухал.

Тухайн сургуулиасаа хамаараад шаардагдах оноо өөр өөр байх ч, багадаа IELTS 6.0-6.5+, TOEFL 70-80+ оноотой байхыг шаарддаг.



АВСТРАЛИ УЛСАД
МАГИСТРЫН ТҮВШИНД
ТЭТГЭЛЭГ АВАХАД
ЮУ ЮУ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Австрали улсад магистрын түвшинд тэтгэлэг авахад

Австрали улсын хувьд баклаврын зэргээс илүү магистрын түвшинд суралцахад тэтгэлэг авах боломж их байдаг.

Түүнийгээ дагаад тэтгэлэг авах шалгуурууд нь чангарч, өрсөлдөөнтэй болдог. Тэтгэлгийн хэмжээ нь оюутаны хувийн онцлогоос хамааран өөр өөр байдаг бөгөөд сургалтын төлбөрийн 2000 Автсрали доллараас 100% хүртэл байдаг.

100% тэтгэлгүүд:

- Australian awards
- Endeavour scholarship



ЕРӨНХИЙ ШААРДЛАГА



- АКАДЕМИК ГОЛЧ ДҮН
- ЗОРИЛГО ТОДОРХОЙЛОХ ЭСЭЭ
- CV/ТОВЧ НАМТАР
- ХЭЛНИЙ ОНОО
- ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ
- GRE ШАЛГАЛТЫН ОНОО

АКАДЕМИК ГОЛЧ ДҮН

- Баклаврын зэрэгтэй байх
- Голч дүнгийн хувьд хамгийн багадаа **3.3 GPA 80%**-с дээш дүнтэй байхыг зөвлөж байна.
- GRE шалгалтын оноо өндөр байх туслах давуу талтай.
- First class honours болох Австралийн ахлах сургуульд өндөр гэж тооцогдох дүнг авахыг зөвлөдөг.

ЗОРИЛГО ТОДОРХОЙЛОХ ЭСЭЭ

- Суралцах төлөвлөгөө, суралцагчийн ирээдүйн зорилго, судалгааны ажлын төлөвлөгөөг тэтгэлэг олгохдоо их чухалчилж үздэг.

CV/ТОВЧ НАМТАР

- Баклаврын зэргийн хугацаанд болон төгссөнөөс хойших таны хийсэн төсөл, судалгааны ажил, дадлагын болон бүтэн цагын ажилуудаар таны ур чадвар, хүсэл эрмэлзэл, алсын хараа зэргийг тань дүгнэнэ.

ХЭЛНИЙ ОНОО

- Австрали улсад тэтгэлэг авахад хэлний оноо маш том шалгуур болж өгдөг.
- Их сургуулиуд тэтгэлэг олгохдоо суралцагчидаас дор хаяж **IELTS 6.0-6.5+**, **TOEFL 70-80+** оноотой байхыг шаарддаг.

ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

- Их сургуулийн профессор, мэргэжлийн багш нараасаа тодорхойлох захидал авах шаардлагатай.
- Энэ захидал нь суралцагчийн академик чадвар, идэвхи оролцоог таниулж өгдөг тул Австрали улсын Их сургуулиуд чухалчилж авч үздэг.

АМЖИЛТ ХҮСЭЭ!

